

Завхан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
хуралдааны 2023 оны 04. дүгээр сарын 08.-ны
өдрийн 21. дүгээр тогтоолын 1. -р хавсралт



“НЭЭЛТТЭЙ ЗАВХАН АЙМАГ” ХӨТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг УИХ-аар батлуулан хэрэгжилтийг бүх шатанд ханган ажиллаж байна. Тус бодлогын баримт бичигт боомт, эрчим хүч, аж үйлдвэржилт, хот, хөдөө, ногоон хөгжил, төрийн бүтээмж зэрэг 6 багц асуудал тусгасан.

Хот хөдөөгийн сэргэлтийн хүрээнд орон нутгийг хөгжүүлэх, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьших иргэдийн ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг нэмэгдүүлэх, орон нутагт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжих зорилгоор “Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 419 дүгээр тогтоол, Засгийн газрын хуралдааны 56 дугаар тэмдэглэл гарсан.

Дээрх шийдвэрүүдийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 157-р захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2022-2024 онд хэрэгжүүлэх ажлын ерөнхий төлөвлөгөөгөөр салбарын яам, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн авч хэрэгжүүлэх ажлын чиглэлүүдийг баталсан.

Нутгийн удирдлагын байгууллага, бүх шатны хурлын Төлөөлөгчид, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилга, оролцоотойгоор “Алсын хараа-2050 урт хугацааны бодлого”, “Шинэ сэргэлт”-ийн бодлогын үзэл баримтлалд нийцүүлэн аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт орон нутгийн онцлогийг тусгасан бие даасан хөтөлбөр батлан, хэрэгжүүлэхээр нэмэлт оруулах хэрэгцээ шаардлага гарч байна.

Иймд манай аймаг орон нутгийн өнөөгийн нөхцөл байдал, нөөц боломж, аймгийн түүх, соёл, зан заншил, уламжлал, оюун санааны үнэт зүйлс, нийгэм, эдийн засаг, техник, технологи, үндэсний үйлдвэрлэлийн ололт амжилтыг шилжин ирэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд мэдээлэн сурталчлах “Нээлттэй Завхан аймаг” хөтөлбөр (цаашид “Хөтөлбөр” гэх)-ийг холбогдох бодлогын бичиг баримт, хөтөлбөр, үйл ажиллагаа, судалгаанд үндэслэн боловсруулсан болно.

ХОЁР. ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

2.1. Завхан аймгийн нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал

Завхан аймаг нь засаг захиргааны 24 сум, 116 багтай. Аймгийн дүнгээр 1 км.кв талбайд 0.88 хүн ноогдож байгаа нь улс, бүсийн дундажтай харьцуулахад хүн амын нягтаршил бага байна.

2021 оны эцсийн байдлаар 21.2 мянган өрхийн 73.8 мянган хүн амтай бөгөөд улсын нийт хүн амын 2.2, бүсийн хүн амын 17.6 хувийг бүрдүүлж байна. Хүн амын 22.5 хувь нь аймгийн төвд, 77.5 хувь нь сумдад амьдарч байна. Хүн амын 49.9 хувь нь эрэгтэйчүүд, 50.1 хувь эмэгтэйчүүд эзэлж байна.

Завхан аймгийн SWOT шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> • Шилжин ирэгсдийн ихэнх хувь нь хөдөлмөрийн насныхан байна. • Аймгийн хэмжээнд ажиллах хүчний оролцооны түвшин 65,8%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 61.4% байна. • Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр хөтөлбөрүүд хэрэгжиж, үр дүн гарч байна. • Цэвэр агаар, тайван амгалан орчин, түгжрэлгүй замын хөдөлгөөн. • СӨБ-ын хувьд хоттой харьцуулахад нэг цэцэрлэгт оногдох хүүхдийн тоо 26.8%-иар, нэг багшид ноогдох хүүхдийн тоо 19.3%-иар бага. • ЕБС-ийн хувьд хоттой харьцуулахад нэг сургуульд оногдох хүүхдийн тоо 2 дахин, нэг багшид ноогдох хүүхдийн тоо 75.2%-иар бага. 	<ul style="list-style-type: none"> • Жил бүр шилжин ирэгсдийн тооноос шилжин явагсдын тоо 2-3 дахин их байна. Шилжигчдийн тоо буурахгүй байна. • Шилжигсэд нь хүн ам зүйн ачаалал багатай, залуучууд, хөдөлмөрийн насныхан байна. • Хот руу шилжигчдийн тоогоор тэргүүлдэг аймгуудын тоонд багтаж байна. • Шилжигсэд ажлын байр, амьдралын нөхцөл, сайн боловсролын төлөө шилжиж байна. • Хөдөө орон нутгаас хот суурин газарт чиглэсэн шилжилт хөдөлгөөнд гэр бүл, найз нөхөд бие биедээ мөнгөн бус гуйвуулгын хэлбэрээр тусалдаг уламжлал арга барил ажиглагдаж байна. Ерөнхийдөө шилжигсэд уугуул нутагтаа мөнгөн болон мөнгөн бус гуйвуулга илгээхээс илүүтэйгээр хүлээн авч байна. • 2.1 мянган хүн ажил идэвхтэй хайж байгаа нь ажилгүй хэдий ч ажиллах сонирхол бага байгааг харуулж байна. • Хувийн хэвшлүүдийг үйл ажиллагааны чиглэлд хөдөө аж ахуй, худалдаа гэсэн цөөн салбар ихэнх хувийг эзэлж байна. • Шилжих шийдвэрийг эмэгтэйчүүд дийлэнхдээ гаргадаг байна. • Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж сул, нэг их эмчид ноогдох хүний тоо хотынхоос 1.1 дахин их зэрэг нь шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх түлхэх хүчин зүйлсийн нэг болж байна. • Боловсролын чанар сайн биш байгаа нь шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх түлхэх хүчин зүйлсийн нэг болж байна. • Аймаг орон нутгийн давуу тал, боломж, нөөцийг таниулсан, шилжилт хөдөлгөөний урсгалд нөлөөлөхүйц сурталчилгаа, хөдөлгөөн, компанит ажил, маркетинг сул.
Боломж	Аюул бэрхшээл
<ul style="list-style-type: none"> • Хүн амын нягтрал бага, шилжин ирэгсдийг суурьшуулах боломжтой. • Гэхдээ Улаанбаатар руу очихын өмнө шилжигчид 	<ul style="list-style-type: none"> • Улаанбаатарт шилжин очсон өрхүүд хөдөө орон нутагт цалин хөлс

<p>эхлээд баг, сумын төвөөс аймгийн төв рүү, мөн нэг аймгаас нөгөө аймаг руу шилжин, эцэст нь нийслэл хот руу шилждэг байна.</p> <ul style="list-style-type: none"> • Шилжигчдийн тодорхой хэсэг (24%) ялангуяа, гэр хороололд оршин сууж буй бүртгэлгүй шилжигчид уугуул эсвэл хөдөө орон нутаг руу шилжих хүсэлтэй байна. • Төрийн алба, хувийн хэвшилд багагүй тооны ажлын орон тоо бэлэн байна. • Хотод шилжин очсон хүмүүсийн тодорхой хувь нь бүртгэлгүй, мал хөрөнгөтэйгээ байсаар байгаа нь буцан ирэх магадлалтайг харуулж байна. • Шилжигчдийн орон сууц өмчлөлийн байдал буурсан байна. • Шилжигчид ихэнхдээ нэг удаа шилжээд зогсохгүй, хот дотор эсвэл бусад газар луу 2-3 удаа шилжилт хөдөлгөөн хийх, гадаад улс руу дамжин шилжих хандлага их байна. 	<p>хэт бага, ажлын байр хомс, амьдралын чанар муу зэрэг шалтгааны улмаас буцан шилжих сонирхолгүй байна.</p>
---	--

2.2. Хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал

(2021 оны жилийн эцсийн байдлаар)

Завхан аймгийн хөдөлмөрийн насны хүн ам 45.3 мянга буюу нийт хүн амын 61.3%-ийг эзэлж байна. Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээлд дэх оролцоог авч үзэхэд 29.8 мянга (65.8%) нь ажиллах хүч, 15.5 мянга (34.2%) нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

Ажиллах хүчний оролцооны (ажиллах хүч/хөдөлмөрийн насны хүн ам) түвшин 65.8%, хөдөлмөр эрхлэлтийн түвшин (ажиллагсад/хөдөлмөрийн насны хүн ам) 2021 онд 61.4% болж, үзүүлэлтүүд нь өмнөх оноос 11.5 пунктээр буурсан бөгөөд хөдөлмөрийн насны хүн амын дотор ажиллагчид болон ажил идэвхитэй хайж байгаа иргэдийн тоо буурсныг харуулж байна.


Мөн 27.8 мянган хүн ажил эрхэлж байгаа бөгөөд өмнөх оноос 10.8 хувь буюу 3.3 мянган хүнээр буурсан байна. Нийт ажиллагсдын 18% буюу 5.1 мянга нь төрийн албанд, 81% буюу 22.7 мянга нь аж ахуйн нэгж болон хувиараа хөдөлмөр эрхлэгч, бусад хэлбэрийн ажиллагсад байна.

Нийт ажиллагсдын 45.1% нь хөдөө аж ахуйн салбарт, 15.2 % нь төрийн удирдлага ба батлан хамгаалах, нийгмийн хамгааллын салбарт, 9.4% нь худалдаа, үйлчилгээний салбарт, 8.8% нь боловсролын салбарт, 6.8% нь эрүүл мэндийн салбарт, 14.7% нь бусад салбарт ажиллаж байна.

Аж ахуйн нэгж байгууллага, түүнд ажиллагсад


Манай аймагт нийт 2425 аж ахуй нэгж бүртгэлтэйгээс 1099 буюу 45% нь үйл ажиллагаагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад 21.1 мянган хүн ажиллаж байна. Мөн 216 төрийн байгууллагад 5176 төрийн албан хаагч ажилладаг.

(Ажиллагсад, эдийн засгийн салбарын ангиллаар)




Үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 48.4% нь худалдааны салбарт, 13.3% нь боловсруулах салбарт, 8.9% нь хөдөө аж ахуйн салбарт, 3.8% нь барилгын салбарт, 3.9% нь зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж байна.

(ААН-ийн тоо, үйл ажиллагаа явуулж буй салбараар)



Ажилчдын тооны бүлгээр нь авч үзвэл 868 нь 1-9 ажилтантай, 112 нь 10-19 ажилтантай, 87 нь 20-49 ажилтантай, 32 нь 50-аас дээш ажилтантай байна.

(ААН-үүд ажилчдын тооны бүлгээр)



2021 оны судалгаагаар 1500 хүн хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа гэсэн тоон үзүүлэлт гарчээ.

Ажилгүйдлийн түвшин

2021 онд аймгийн ажилгүйчүүдийн тоо 2.1 мянгад хүрч ажилгүйдлийн түвшин 6.7 хувь болсон нь өмнөх оноос 5.1 пунктээр өссөн байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын 13.8 хувь нь сургуульд сурдаг, 53.8 хувь нь тэтгэвэрт, 13.1 хувь нь хөдөлмөр эрхлэх чадваргүй, 12.7 хувь нь гэрийн ажилтай (жирэмсэн болон хүүхэд асрах), 6.6 хувь нь тохирох ажил олдохгүй байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр¹

Сүүлийн 5 жилийн байдлаар буюу 2017-2021 онд хөдөлмөр эрхлэлтийн дэмжих хөтөлбөрийн хүрээнд “Хөдөлмөрт бэлтгэх - хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох”, “Ажлын байрыг дэмжих”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих -гарааны бизнесийг дэмжих”, “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”, “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ” гэсэн 6 хөтөлбөр, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх үйлчилгээ, ажилд зуучлах үйлчилгээ гэсэн 2 арга хэмжээ хэрэгжсэн байна.

Нийт 4.5 тэрбум төгрөгийн төсвийг тус хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна. Хөтөлбөрт арга хэмжээнүүдэд 10892 иргэн хамрагдаж, 7804 нь буюу 71,6% нь байнгын болон түр ажлын байраар хангагдсан байна.


2.3.Шилжилт хөдөлгөөн, түүнд нөлөөлөгч хүчин зүйл

Завхан аймгийн хүн амын шилжилт хөдөлгөөний сүүлийн 10 жилийн дунджийг харахад жилд шилжин ирж буй хүнээс 2.1 дахин олон хүн шилжин явж байна. Тухайлбал, 2021 онд Завхан аймагт 560 хүн шилжин ирсэн бол үүнээс 2.8 дахин их буюу 1596 хүн шилжин явжээ. Завхан аймгаас нийслэл хот руу шилжигчдийн тоо нь нийт орон нутгаас хот руу шилжигчдийн 5.9%-ийг эзэлж байгаа нь өндөр шилжилттэй аймгуудын тоонд багтаж байна. Нийт шилжилт хөдөлгөөнд нийслэлээс ирэх болон нийслэл рүү шилжих хөдөлгөөн дийлэнх хувийг эзэлж байна.

(Завхан аймагт шилжиж ирсэн, аймгаас

¹ “Завхан аймгийн ХЭДХ-ийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэлд үнэлгээ өгөх нь” төслийн тайлан, 2021

шилжин явсан хүний тоо, сүүлийн 10 жилээр²⁾



Хот руу шилжигч хүн амын шинж байдал³⁾

Орон нутгийн иргэдийг хот руу шилжихэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг авч үзэхэд хотын эдийн засаг, нийгмийн татах хүчин зүйлс (89.3%), уугуул нутаг дахь түлхэх хүчин зүйл (1.2%), гэр бүл, бусад хүнээс хамаарсан хүчин зүйл (1.2%), бусад хүчин зүйл (0.5) гэсэн 4 бүлэг хүчин зүйл нөлөөлж байгаа нь харагдаж байна.

Эдгээр нөлөөлөгч хүчин зүйлсийн улмаас ажлын байртай болох орлогоо нэмэгдүүлэх, амьдралын нөхцөлөө сайжруулах, сайн боловсрол эзэмших гол зорилгуудын төлөө шилждэг байна.

Хот руу шилжихэд нөлөөлөгч хүчин зүйлс

№	Шалтгаан	хувь
Хотын эдийн засаг, нийгмийн татах хүчин зүйл		89.3
1	Хөдөлмөр эрхлэлт, бизнес эрхлэх боломж	38.5
2	амьдралын илүү сайн нөхцөл	21.0
3	Боловсролын чанар илүү /өөрөө/	20.3
4	хүүхдийнхээ боловсрол, ирээдүй амьдралын төлөө	6.4
5	эрүүл мэндийн үйлчилгээ авах, эмчилгээ хийлгэхээр	3.1
Уугуул нутгийн түлхэх хүчин зүйл		1.2
6	уугуул нутагт бэлчээрийн/сууцны зориулалтын газар эзэмших боломж муу	0.4
7	нийгмийн үндсэн, зайлшгүй үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал	0.8
Гэр бүлийн хүчин зүйл		9.0
8	Гэрлэлт	1.5
9	Гэр бүлийн гишүүдийн хамт шилжсэн	5.1
10	Бусад хамаатан садантайгаа ойртох	2.4
11. Бусад хүчин зүйл		0.5

²⁾ 1212.mn

³⁾ Шилжилт хөдөлгөөн ба хөдөлмөр эрхлэлт судалгааны тайлан, МУИС-ХАЗССТ, UNI-MERIT, 2021

Татах, түлхэх хүчин зүйлийн талаас харвал, нийслэл хот болон хөдөө орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн ялгавартай байдал шилжилтийн хамгийн гол хүч болж байна.

Шилжигчдийн хүн ам зүйн болон нийгмийн шинж байдал

Шилжигч өрхийн тэргүүлэгчдийн 74.6 хувь, өрхийн гол тэжээгчдийн 68.7 хувь нь эрэгтэйчүүд байна. Өрхийн тэргүүлэгч залуу, хөдөлмөрийн насны байх тусмаа илүү шилжилтэд оролцож байна.



Шилжигчдийн дунд хөдөлмөрийн насныхан илүү өндөр хувийг (50-иас дээш) эзэлж байна.

Мөн харьцангуй бага хүн ам зүйн ачаалалтай хэсэг нь шилжиж байна.

Хүн ам зүйн ачаалал, харьцуулалтаар

Шилжигчдийн гэрлэлтийн байдлыг харвал гэрлээгүй 30, хамт амьдардаг 20, гэрлэсэн 40, салсан эсвэл бэлэвсэн 10 орчим хувийг эзэлдэг байна.

Боловсролын түвшний хувьд бага түүнээс доош 2.4, бүрэн дунд 51.3, техник мэргэжлийн 9.3, дээд 34.6, ахисан түвшний боловсролтой иргэд 2.4 хувийг эзэлдэг байна.

Завхан аймгаас хот руу шилжигчдийн 70 орчим хувь нь бүртгэл хийлгэсэн, 30 орчим хувь нь бүртгэл хийлгээгүй байна.

Шилжигчдийн өрхийн шинж байдал

Шилжигч өрхүүд хотод очоод гэрт 20, орон сууцанд 53.9, сууцны тусдаа байшинд 15.9, нийтийн байранд 10.1, бусад сууцанд 0.1 хувь нь амьдарч байгааг аймгийн хүн амын сууцны нөхцөлтэй харьцуулахад илүү сайн нөхцөлтэй харагдаж байна.

Хот руу шилжин очсон өрхүүдийн 10 гаруй хувь нь төвлөрсөн, үлдсэн хувь нь худаг, зөөврийн усан хангамжтай орчинд амьдарч байгаа нь аймгийн нөхцөлтэй харьцуулахад харьцангуй (10%-иар) доогуур үзүүлэлттэй байна. Шилжин очсон өрхүүдийн хувьд ариун цэврийн байгууламж (бие засах газар) илүү сайжирсан байна.

Шилжигч өрхүүдийн хувьд бараг бүгд тодорхой тооны малтай хэвээр байгаа бөгөөд шилжигч өрхүүд (ялангуяа бүртгэлгүй шилжигч өрх) илүү олон малтай байна. Энэ нь магадгүй, бүртгэлгүй шилжигч өрхүүд эргээд нутаг орон руугаа буцах хүсэлтэй (шилжин ирсэн газраа бүртгүүлж чадаагүй) учраас малаа хадгалж байж болох талтай.

Сууц өмчлөлийн байдлыг шилжилтийн өмнөх ба дараах байдлаар харьцуулахад мэдэгдэхүйц ялгаа ажиглагдаж байна. Шилжихээс өмнө, нийт шилжигч өрхийн дийлэнх нь өөрийн эзэмшлийн сууцанд амьдардаг байв. Харин шилжилтийн дараагаар 49.4 хувь нь л өөрийн эзэмшлийн сууцандаа амьдарч, сууц өмчлөлийн байдал 27.2 пунктээр буурсан байна. Ялангуяа, бүртгэлгүй шилжигчдийн хувьд энэ үзүүлэлт даруй 43 пунктээр буурчээ.

№	Өрхийн сууц эзэмшлийн байдал	шилжихээс өмнө	шилжсэний дараа	Өсөлт бууралт
1	Өөрийн эзэмшлийн сууцанд	76.6	49.4	-27.2
2	Бусдын өмчлөл түрээстэй болон түрээсгүйгээр	23.4	45.6	22.2
3	Бусад	0	3	5.0
4	Нийт	100	100	

Эндээс, шилжилт хөдөлгөөний дараагаар шилжигчдийн сууц өмчлөлийн байдал муудсан гэж хэлж болно. Энэ нь хотын зах зээл дээр орон сууцны үнэ өндөр, шилжигчид сууц худалдан авахаасаа илүүтэй тодорхой хугацаанд түрээслэхийг эсвэл хэн нэгний эзэмшил байранд амьдрахыг илүүд үзсэнтэй холбоотой байх талтай. Нөгөө талаар, мөн шилжигчдийн, ялангуяа, бүртгэлгүй шилжигчдийн худалдан авалтын чадвар муу байгааг илтгэж ч болно.

Шилжигчдийн 67% нь албан ёсны зөвшөөрөл бүхий газар, 26% нь албан ёсны бус газар, 7% бусад газар амьдарч байна.

Шилжилтийн өмнөх ба дараах өрхийн амьдралын ерөнхий байдлын харьцуулалтаар ерөнхий нөхцөл байдал, тухайлбал, орлого (61.0%), мэргэжлийн ур чадвар (59.0%), амьдралын нөхцөл (57.6%), хөдөлмөр эрхлэлт (53.4%) сайжирсан гэжээ.

Шилжин ирсний дараагаар ажил хайх, нийгмийн халамжийн үйлчилгээ авах, эрүүл мэндийн үйлчилгээ авахад тулгарсан бэрхшээлүүд хамгийн гол 3 хүндрэл сорилтод тооцогдож байна. Ялангуяа, бүртгэлгүй шилжигчдийн хувьд эдгээр бэрхшээл өндөр хувьтай байна. Бизнесийг бүртгэх, дэд бүтцийн үйлчилгээ, аюулгүй байдал, зээл авах, хүүхдийн боловсролын үйлчилгээ, газар эзэмших, байшин түрээслэх, худалдан авахтай холбоотой сорилтууд тус бүр 1-6 хувийг эзэлж байна.

Шилжигчдэд тохиолдож буй хүндрэл бэрхшээл тэдний оршин суугаа газраа бүртгэл хийлгэсэн эсэхээс ихээхэн хамаардаг байна.

Шилжилт хөдөлгөөнд гэр бүл, найз нөхөд бие биедээ мөнгөн бус гуйвуулгын хэлбэрээр тусалдаг уламжлал арга барил ажиглагдаж байна. Ерөнхийдөө шилжигчдэд уугуул нутагтаа мөнгөн болон мөнгөн бус гуйвуулга илгээхээс илүүтэйгээр өөрсдөө хүлээн авах нь их байна.

Шилжигчдийн шилжилтийн өмнөх ба дараах ажил эрхлэлтийг харьцуулахад ажил эрхлэлт 46.8 хувиар өссөн, ажилгүй хүний тоо 79.7 хувиар буурсан, ажиллах хүчнээс гадуурх хүний тоо 64 хувиар буурдаг байна. Хөдөлмөр эрхэлж буй шилжигчдийн хамгийн өндөр хувь эзэлж буй гурван салбарыг харвал, шилжин очихоосоо өмнө 1) хөдөө аж ахуй, 2) бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ, 3) барилгын салбарт ажилладаг байсан бол шилжин очсоны дараа 1) барилга, 2) бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ, 3) тээвэр ба агуулахад ажиллаж байна. Шилжилтийн өмнө цалинтай ажил эрхлэгч 51.2 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгч 46.9 хувь, бусад ажил эрхэлдэг 1.9 байсан бол, шилжилтийн дараа харгалзан 76.4, 23.1, 0.5 хувь болж өөрчлөгджээ. Харин шилжилтийн дараагаар хувиараа хөдөлмөр эрхлэгч шилжигчдийн 90-ээс илүү хувь нь бизнес эрхлэгчид, үлдсэн 7.4 хувь нь мал аж ахуй эрхэлдэг байна. Шилжилт

хөдөлгөөнд оролцохоосоо өмнө шилжигчдийн бараг тал хувь нь хөдөлмөрийн гэрээгүйгээр ажилладаг байжээ. Гэхдээ шилжилтийн дараагаар энэ хувь буурч, шилжигчдийн гуравны нэг нь л хөдөлмөрийн гэрээгүйгээр ажил эрхэлж байгаа аж. Ерөнхийдөө, шилжигчдийн хувьд тогтсон хугацаатай гэрээ бүхий хөдөлмөр эрхлэлтэд оролцох байдал нэмэгдсэн байна.

Шилжигчдийн бараг тал нь Улаанбаатар хотод шилжин ирснээсээ хойш хот дотроо ямар нэг байдлаар дахин шилжсэн байна. Нийт шилжигчдийн 26.8 хувь нь нэг удаа, 15.3 хувь нь 2 удаа шилжжээ. Гэр хороололд амьдардаг шилжигчид байшин хороололд амьдардаг шилжигчидтэй харьцуулахад илүү олон шилжсэн байна. Дунджаар, ядаж нэг удаа хот дотроо шилжин ирснээсээ хойш шилжилт хийжээ.

Ерөнхийд нь дүгнэхэд, шилжигчид шилжилт хөдөлгөөнд оролцсоноор шилжилтийн эцсийн зорилго амжилттай биелүүлсэн байна: шилжилт хөдөлгөөн амьдралын нөхцөлөө сайжруулах, боломжийн ажилтай болох, сайн боловсрол эзэмшихэд тусалжээ.


2.4. Завхан аймагт шилжин ирэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих хэрэгцээ, шаардлага, үндэслэл

Уугуул нутаг орон эзгүйрэх аюулаас сэргийлэхийн тулд:

Завхан аймгийн нийт хүн амын өөрчлөлт	2001/2011	хувь	2011/2021	хувь
		-20892	-25%	10135

(Аймгийн хүн амын тооны өөрчлөлт, тоогоор, хувиар)

Сүүлийн 20 жилийн байдлаар аймгийн хүн амын тоог авч үзэхэд 2001 оноос 2011 онд нийт 20.8-аар мянга буюу 25 хувиар буурсан, 2021 онд 2011 оноос 10.1 мянга буюу 12 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2021 оны 2001 онтой харьцуулахад хүн амын тоо 13 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



(хүн амын тоо, сумдаар)

2001 онд 1500-аас доош тооны хүн амтай сумын тоо 2 байсан бол 2011 онд 8, 2021 онд 5 байна. 1500-3000 хүн амтай сумын тоо 2001, 2011 он 13 байсан бол 2021 онд 15 байна. 3000-5000 хүн амтай сум 2001 онд 6 байсан бол 2021 онд 1 байна. Эндээс харахад сумдын хүн амын тоо цөөрч, ихэнх сумд 3000 хүртэлх хүн амтай байгаа нь уугуул нутаг эзгүйрэх, нөгөө талаас орон нутгийн үйлдвэрлэл хөгжих зах зээлийн боломж багасаж байна.

Ажиллах хүчний хэрэгцээ:

д/д	Салбарын ангилал
1	Боловсролын салбарт -17 <ul style="list-style-type: none"> • Ерөнхий боловсролын сургуульд багш – 10 • Сургуулийн өмнөх боловсролд багш -7
2	Эрүүл мэндийн салбарт - 60 <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндийн газарт салбар хариуцсан мэргэжилтэн – 7 • Их эмч -20 • Бага эмч – 22 • Сувилагч – 7 • Лаборант – 3 • Эмийн санч -1
3	Хөдөө аж ахуйн салбарт -17 <ul style="list-style-type: none"> • Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан чиглэлд– 9 • Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, үржил бүртгэл мэдээлэл хариуцсан чиглэлд - 2 • Хоол үйлдвэрлэл, нийтийн хоол худалдаа үйлчилгээний чиглэлд – 1 • Бэлчээр, газар тариалангийн чиглэлд - 5
4	Хууль сахиулах, төрийн тусгай чиг үүргийн салбарт – 16 <ul style="list-style-type: none"> • Цагдаагийн байгууллагад -15 • Улсын бүртгэлийн байгууллагад -1

Аж ахуйн нэгж болон хувиараа хөдөлмөр эрхлэгчийн бий болгох ажлын байрны тоо

3 жилийн давтамжит “Завхан аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа”-ны үр дүнгээс харахад:

Жилд нэмэгдэх байнгын болон түр ажлын байрны судалгааг гаргахад байнгын ажлын байр 60 нэр төрлийн мэргэжлийн хувьд 253, түр ажлын байр 34 нэр төрлийн мэргэжлийн хувьд 201 ажлын байр тус тус шинээр бий болох хандлага ажиглагдаж байна.

Жил бүр хүн амын тоо өсч байгаа, үйлдвэрлэл үйлчилгээ тодорхой хэмжээнд өргөжиж байна. Эдгээр бизнес эрхлэгч байгууллагууд ашигтай, өсөж буй өргөжилттэй байх тохиолдолд үүнээс ч илүүгээр ажлын байрыг нэмэгдүүлэх боломжтой.

Эхний ээлжинд бэлэн байгаа ажлын байрыг шаардлагатай боловсон хүчнээр хангахын тулд төр засгаас хөдөлмөрийн эрэлтийг бий болгогч аж ахуй нэгж, нийлүүлэлтийг бий болгогч хувь хүмүүс, зуучлагч байгууллагуудыг мэдээллээр хангах, үйл ажиллагааны хоорондын холбоог бий болгоход ихээхэн анхаарч ажиллах хэрэгтэй

бол цаашид ажлын байрыг нэмэгдүүлэхэд төр засаг, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, үр өгөөжийг нэмэгдүүлэх тал дээр анхааран ажиллах хэрэгтэй.⁴

**Завхан аймагт жилд шинээр бий болж буй ажлын байруудад
шаардлагатай мэргэжлүүд, чиглэлээр**

Шаардлагатай мэргэжил		
Авто машин засварчин	Сувилагч	Худалдагч
Борлуулагч	Талх нарийн боовны ажилтан	Хүний нөөцийн мэргэжилтэн
Гагнуурчин	Тариаланч, ногоочин	Хэв баригч хивэнд оруулагч
Хөтөч	Техникч	Цахилгааны инженер
Гоо сайханч	Технологич	Цахилгаанчин
Гуталчин	Тогооч	Эм найруулагч
Жолооч	Төмөр хийцийн мэргэжилтэн	Угсрагч
Зөөгч, бармен	Туслах ажилтан	Үйлчлэгч
Их эмч	Туслах тогооч	ХААБ менежер
Компьютерийн мэргэжилтэн	Орчуулагч	ХАБЭАЖ ажилтан
Малчин	Сийлбэрчин	Хөрөө, рамчин
Малын эмч	Оёдолчин	Мужаан
Манаач	Ойн инженер	Нэхмэлчин
Менежер, зохион байгуулагч	Механикч	Цэцэрлэгийн багш
Бага ангийн багш	Сэтгэл зүйч	

2.5. Хотоос шилжин ирэгсдийг татах бусад нөөц боломжууд

Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд аймгийн эдийн засгийн нөөцөд тулгуурласан хөгжил, нийгмийн үйлчилгээ ба хүний хөгжил, ногоон хөгжилд суурилсан орон нутгийн хөгжлийг тулгуур чиглэл болгон тодорхойлж, хэрэгжүүлж байна. Үүнтэй холбоотойгоор холбогдох салбаруудыг хөгжүүлэх, цаашлаад ажлын байрыг тоог нэмэгдүүлэх, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зэрэг боломжууд байна.

Мал аж ахуйн салбар дахь нөөц

Хөдөө аж ахуйн 6973.7 га талбайтай, мал аж ахуйг 5 төрлөөр өсгөн үржүүлдэг бөгөөд 2021 оны байдлаар 3.7 сая толгой малтай. Хөдөө аж ахуйн салбарт тулгуурласан эдийн засагтай бөгөөд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 54.9 хувийг бүрдүүлдэг. Мал аж ахуйн салбараас мах, сүү, арьс шир, ноос, ноолуур, хөөвөр зэрэг түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэгдэж байгаа бөгөөд эдгээр нөөцийг нэмэгдүүлэх,

⁴ Завхан аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаа, 2018, 2021, Улиастай.

боловсруулах, шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, жижиг дунд гэлтгүй томоохон үйлдвэрийг хөгжүүлэх боломжууд байна.

Тухайлбал, Идэр, Тэлмэн, Их-Уул, Тосонцэнгэл суманд хийгдсэн малын гаралтай бүтээгдэхүүний нөөцийн судалгаанаас харахад тус сумдад аймгийн нийт үхэр сүргийн 32%, хонин сүргийн 21%, сарлагийн 52% нь нутаглаж байна. Эдгээр малаас гарах түүхий эдийн нөөц их байгааг харуулж байгаа юм.

Газар зүйн байрлалын хувьд ойрхон байрладаг тул эдгээр сумдад кластер загвараар үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх боломжтой. Эдгээр сумд нь жилд сарлагийн хөөвөр 18 тонныг буюу аймгийн хөөврийн нөөцийн 52%-ийг, үхрийн сүү 191 тонныг буюу аймгийн үхрийн сүүний нөөцийн 34%-ийг, 458 тонн хонины ноос буюу аймгийн нийт ноосны нөөцийн 22%-ийг гаргах боломжтой байна. Сумдын үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааны чиглэлийг харахад сүү сүүн бүтээгдэхүүн болон ноосны үйлдвэрлэл тодорхой хэмжээгээр байгаа бол сарлагийн хөөврөн бүтээгдэхүүн үйлдвэрлэл байхгүй байна.

2.6.Завхан аймагт амьдрах, хөдөлмөрлөх боломж

- ✓ Улиастай сумын Өлзийт багийн нутаг дэвсгэрт “Шинэ Завхан” төслийг эхлүүлж, 800 айлын орон сууцыг барьж байгуулахаар ТЭЗҮ хийгдэж, ажил эхэлсэн.
- ✓ Тус төслийн хүрээнд 150 хүүхдийн цэцэрлэг, 640 хүүхдийн сургууль, спорт заал барихаар хөрөнгийг улсын төсөвт суулгах ажил эхэлсэн.
- ✓ Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд “Арц суурь-Нарийн сухайт - Шивээ хүрэн” чиглэлийн 1255 км төмөр замын төслийг эхлүүлсэн.
- ✓ Ипотекийн зээлд хамрагдаж байгаа иргэдийн ипотекийн зээлийн хүүгийн 3 хувь, урьдчилгаа төлбөрийн 30 хувийн 60 хувийг төр батлан даана.
- ✓ Ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгоор, бизнес эрхлэх иргэн, аж ахуйн нэгжүүдэд 1%-ийн хөнгөлөлттэй зээл олгоно.
- ✓ Орон нутагт ажиллаж буй төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдлийг 20 хувиар тооцож олгоно.
- ✓ Боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргааны салбарт ажиллаж буй сумдын төрийн албан хаагчдад 5 жил тутам 6 сарын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг олгоно.
- ✓ Орон нутагт дутагдалтай үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт бизнес эрхлэх боломжтой.
- ✓ Хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарыг түлхүү хөгжүүлэх бодлогыг баримталдаг тул тус салбарт үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлнэ.

- ✓ Шилжин суурьшигчдад дэмжлэг үзүүлэх бодлого, зорилт, арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлж байгаа тул мэдээлэл, зөвлөгөө авах боломжтой.

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1. "НЭЭЛТТЭЙ ЗАВХАН ХӨТӨЛБӨР"-ийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

2.1.1. Монгол Улсын хууль, хөгжлийн бодлогын баримт бичиг, холбогдох үндэсний хөтөлбөрүүд, аймаг орон нутгийн бодит нөөц бололцоо, бүс нутгийн эдийн засгийг кластержуулан хөгжүүлэх, орон нутаг өөрийгөө бие даан санхүүжүүлэх эдийн засгийн бодлогод тулгуурлах;

2.1.2. Хөтөлбөрийн агуулгад аймаг орон нутагт шилжин ирэх, орон нутагтаа тогтвортой ажиллаж, амьдрах (нутагтаа үлдэх) үйл ажиллагаа эрхлэн явуулахад үүсэх давуу тал болон үүсч болзошгүй хүндрэл бэрхшээлийг зөв тооцож тусгахыг эрмэлзэн мэдээллийг нээлттэй, тэгш, хүртээмжтэй түгээхийг чухалчилсан, хувь хүн, ААН, байгууллагад хуулиар олгогдсон эрхийг дээдлэн хүндэтгэсэн, үүрэг хариуцлагыг ухамсарлуулан таниулж хандлагын өөрчлөлтөд уриалсан, бизнесийн орчны тэгш боломж, шударга өрсөлдөөнийг эрхэмлэсэн, хөгжил дэвшил, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын таатай орчин, олон талт харилцааны онцлогуудыг уялдуулан тодорхойлсон байх;

2.1.3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд иргэд олон нийт, аж ахуйн нэгж, байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, бизнесийн болон мэргэжлийн холбоодын оролцоог түлхүү дэмжих.

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

3.1. Хөтөлбөрийн зорилго нь аймагт шилжин ирж суурьших, ажиллаж амьдрах шилжин ирэгсдийн тоог нэмэгдүүлэх, мөн нутагтаа тогтвортой, суурьшилтай ажиллаж хөдөөгөөс хот руу шилжих шилжилтийг багасгах, хотоос хөдөө рүү чиглэсэн шилжилтийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг бодлогоор дэмжиж, хамтарч ажиллах замаар аймгийн хүн амын бодит өсөлтийг одоогийн хүн амын 10 хувьд хүргэх.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

4.1. "Нээлттэй Завхан хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхдээ дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

4.1.1. Шилжин явагсдын тоог бууруулах, шилжин ирэгсдийн тоог нэмэгдүүлэхэд нөлөөлөхүйцээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах (боловсрол, эрүүл мэнд, шилжин ирэгсдийн бүртгэл);

4.1.2. Аймгийн онцлог, түүх, соёл, нөөц, боломжид суурилан хотоос ирэх, орон нутагтаа тогтвортой ажиллах иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлэхэд нөлөөлөх, аймаг руу татах хүчин зүйлсийг нэмэгдүүлэх, түлхэх хүчин зүйлсийг бууруулах замаар эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх;

4.1.3.Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, түүний үр дүнг орон нутаг руу татах зорилго, түүнд нөлөөлөх хүчин зүйлстэй уялдуулах;

4.1.4.Шилжин явагсдын тоог бууруулах, шилжин ирэгсдийн тоог нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах боломж бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллага руу чиглэсэн бодлого, хөтөлбөр, дэмжлэг, арга хэмжээ, хөрөнгө оруулалт, нөхцөл байдлын талаар танилцуулга, сурталчилгааг зохион байгуулж, үр дүнд хүрэх;

4.1.5.Шилжин явагсдын тоог бууруулах, шилжин ирэгсдийн тоог нэмэгдүүлэхэд төр, иргэний нийгмийн байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэд зэрэг талуудын оролцоо, хамтын ажиллагааг бий болгох, сайжруулах.

ТАВ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

5.1.“Нээлттэй Завхан аймаг” хөтөлбөрийг дараах чиглэлд тэргүүн ээлжинд хэрэгжүүлнэ:

5.1.1.Амьдрах таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг өргөтгөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, уялдаа холбоог хангах, хөрөнгө оруулалт татах чиглэлд идэвх санаачилга гаргах;

5.1.2.Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтын ажиллагааг идэвхжүүлж аймагтаа ажлын байр нэмэгдүүлэх;

5.1.3.Боловсрол, эрүүл мэндийг салбарын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

5.1.4.Үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, аймгийн брэнд бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон сурталчлах; үйлдвэрлэл, аялал жуулчлал гэх мэт бодит хөрөнгө оруулалт оруулах салбараа эрэмбэлэн хөгжүүлэх, иргэдийн тогтмол орлого олох боломжийг эрэлхийлэх;

5.1.5.Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг эрчимжүүлж, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг мэдээллээр хангах, тэднийг аймаг орон нутагт шилжин ирж суурьших, нутагтаа тогтвор суурьшилтай ажиллах, амьдрах сэдлийг төрүүлэх, хандлагыг өөрчлөх, амьдрах таатай орчин бүрдүүлэх, мэдээллээр хангах чиглэлд аймаг, орон нутаг манлайлан оролцож, эдгээрт чиглэсэн үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг зохион байгуулж тогтмолжуулах;

5.1.6 Хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад тавих хяналтыг нэмэгдүүлэх.

ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

6.1.Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий дэд ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх) ажиллана. Ажлын хэсгийн ахлагч нь Монгол Улсын ерөнхий сайдын 157 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гишүүн, аймгийн засаг даргын орлогч байна.

6.2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга батална. Ажлын хэсэг нь 15 хүртэл гишүүнтэй байх бөгөөд (хамтын ажиллагаа, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж

ажуй, аялал жуулчлал, газрын харилцаа, хэвлэл мэдээллийн болон санхүү, төсөв, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн гэх мэт) ажилтны төлөөлөлтэй байна. Түүнчлэн УБ хот дахь нутгийн зөвлөл, бизнесийн байгууллага, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоод, эрдэмтэн судлаачдын төлөөллийг зөвшилцлөөр оруулж болно.

6.3. Ажлын хэсэг аймгийн хэмжээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж аймгийн Засаг даргаар батлуулна.

6.4. Аймгаас мэдээллээ нээлттэй түгээх зорилгоор Улаанбаатар хот болон бүс нутгийн түвшинд зохион байгуулагдах үзэсгэлэн худалдаа, форум, хурал зөвлөгөөн, спорт, соёл урлагийн арга хэмжээнд оролцож аймгаа сурталчлах асуудлыг ажлын хэсгийн ахлагч шийдвэрлэх ба шаардлагатай тохиолдолд аймгийн Засаг даргатай зөвшилцөн Засаг даргын зөвлөлийн хурал болон ИТХ-ын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

6.5. Дэд ажлын хэсэг олон нийтэд мэдээлэл хүргэх, сурталчлах, үйл ажиллагааг Засгийн газрын дэргэдэх Ажлын хэсэгтэй хамтран нэгдсэн журмаар зохион байгуулах бөгөөд аймгийн хэмжээнд шинээр буй болсон ажлын байр, тухайн салбарт дутагдаж буй шаардлагатай боловсон хүчний судалгаа, шилжилт хөдөлгөөний бүртгэл зэрэг аймгийн нээлттэй мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн байна. Улмаар төв мэдээллийн сантай мэдээлэл солилцох ажлыг орон нутаг дахь бүртгэл хариуцсан ажилтан шуурхай зохион байгуулна.

6.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад ажлын хэсгээс тогтмол хяналт тавьж, хагас болон бүтэн жилээр хэрэгжилтийг дүгнэн хэлэлцэж, аймгийн Засаг дарга, ИТХ, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнана.

ДОЛОО. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

7.1. Хөтөлбөрийн эхний шатыг 2023-2024 оны 1 дүгээр улирал дуустал нийт 15 сарын хугацаанд хэрэгжүүлнэ.

НАЙМ. ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР

8.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээр бүрдүүлнэ:

8.1.1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

8.1.2. Хөгжлийн хөтөлбөрүүд, олон улсын байгууллагын тусламжийн хөрөнгө;

8.1.3. Хувийн хэвшлийн хандив, тусламжийн хөрөнгө;

8.1.4. Бусад.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу тухайн жилийн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн аймгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

ЁС. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

9.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ:

9.1.1. Аймагт шилжин ирсэн иргэдийн бодит тоон өсөлт 10%-иас (зарим аймаг 20%) дээш нэмэгдсэн эсэх;

9.1.2. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, бүтээн байгуулалт, аялал жуулчлал гэх мэт бүх төрлийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн тоо;

9.1.3. Аймаг орон нутагт шинээр бий болсон ажлын байрны тоо;

9.1.4. Иргэд, ААН байгууллагууд, олон нийт рүү чиглэж тэдгээрийг татах чиглэлээр зохион байгуулсан ажлууд, түүний үр дүн;

9.1.5. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тоот тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын “Хүн амын нэмэгдэлтийн хувь, төсвийн байгууллага, хуулийн этгээд тэдгээрийн салбар нэгжийн болон албан хаагчийн шилжилтийн хувь” шалгуур үзүүлэлтээр хэрхэн дүгнэгдсэн байдал;

9.2. Ажлын хэсэг хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт бүрээр хүрэх зорилтот үзүүлэлтийг жил бүр тогтооно.

---oOo---